



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/05

Номгон

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг
хангах дэд зөвлөлийн 2026 оны
төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлөөс 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав), Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа (Т.Цэвээндорж) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



626010013

Аймгийн Засаг даргын 2026 оны 07 дүгээр сарын 05-ны өдрийн 4/05 дугаар захирамжийн хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛӨӨС
2026 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах нэгж
1	2	3	4	5	6	7
Нэг.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент						
1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, чадавхыг бэхжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг цогц байдлаар шинжлэн судлах бие даасан, хараат бус тогтолцоог бүрдүүлнэ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдыг давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулах.	-	Салбар тус бүрт жилд 3-аас доошгүй сургалт зохион байгуулсан байна.	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн тасаг
2	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан хэсэгчилсэн /тухайн нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх/, бүс нутаг, салбар бүрийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.	Сумдын засаг дарга нар Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан төлөвлөгөөг Засаг захиргааны нэгжийн хүрээнд тус бүр боловсруулан хэрэгжүүлэх		Төлөвлөгөөний биелэлтийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлд хагас, бүтэн жилээр ирүүлнэ.	Хагас бүтэн жилээр	Сумын Засаг дарга нар
3		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад тулгамдаж байгаа 1-2 үйл ажиллагааг сонгон хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлнэ.		Мотоцикл, Согтуу, Хурд зэрэг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсан байна	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн тасаг

1	2	3	4	5	6	7
4	Авто тээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох замаар төр, иргэнд ирэх санхүүгийн дарамтыг багасгана	"А" ангиллын тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлэх, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах		Жолооч, тээврийн хэрэгслийн даатгалыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох судалгаа хийгдсэн байна.	Жилдээ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
Хоёр. Аюулгүй зам						
5	Авто тээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох замаар төр, иргэнд ирэх санхүүгийн дарамтыг багасгана;	Зам, явган хүний гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ойлгомтой байдлаар стандарт шаардлагад нийцүүлэн засварлах.		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгийн ойролцоо явган хүний гарц, тэмдэг тэмдэглэгээг засварлах.	Жилдээ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
6		Явган хүний гарцыг тооцоо, судалгааны үндсэн дээр засварлах, гэрлэн дохио суурилуулж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах.		Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Жилдээ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
7	Нийтийн хэрэгцээний замаас бусад газар хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бүрдүүлэх	Уул уурхайн замд хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээ хийж, шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ суурилуулах.		Уул уурхайн 1-ээс доошгүй замд үнэлгээ хийж, холбогдох дүгнэлтийн дагуу өөрчлөлт хийсэн байна.	Жилдээ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
8	Улсын болон орон нутгийн чанартай авто замын дагууд тээврийн хэрэгслийн зөрчлийг хянах дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх	Улсын чанартай зам дагуу хяналтын тоног төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн зөрчлийг хянах.		Улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу тээврийн хэрэгслийн зөрчил дутагдалыг арилгах, арга хэмжээ авах	Жилдээ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Замын цагдаагийн тасаг
Гурав. Аюулгүй хөдөлгөөнд оролцогч						
	Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох	Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, шалгах үйл ажиллагаанд		Холбогдох журамд өөрчлөлт оруулж жолооч бэлтгэх, шалгалт авах шилдэг арга,	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл,

1	2	3	4	5	6	7
		хүний хамаарлыг багасгаж, үр ашигтай техник технологийг хэрэглэх.		шийдлийг хэрэгжүүлж эхэлсэн байна.		Замын цагдаагийн тасаг
10	Замын хөдөлгөөнд оролцогчийн хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлэх	Мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байтуулах.		Үйл ажиллагааг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлагдсан байна.	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн тасаг
11		Төрийн болон хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын анхаарлыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хандуулж, хууль тогтоомжийн хүрээнд сургалт сурталчилгаа явуулах.		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд оролцох нөхцөл хангагдаж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг аж ахуйн нэгжүүд дэмжсэн байна.	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн тасаг
12		Хамгаалах бүс, хамгаалалтын малгай, хүүхдийн суудал, бусад аюулгүйн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр компанит ажлыг үе шаттай, системтэй хэрэгжүүлэх.		Хамгаалах бүс, хамгаалалтын малгай болон бусад аюулгүйн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлсэн байна. Судалгаа хийнэ	Жилдээ	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, Замын цагдаагийн тасаг

_____оОо_____